



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 онд 05 сарын 16 өдөр

Дугаар А/306

Есөнбулаг

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.15 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.2, 28 дугаар зүйлийн 28.1.4 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 10, 11 дүгээр тогтоол, Хууль зүй, дотоод хэргийн сайд Говь-Алтай аймгийн Засаг даргатай 2023 онд хамтран ажиллах гэрээ, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2023 оны 22 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Иргэдээс архидалт ихэсч байгаатай холбоотой гомдол ирүүлснийг үндэслэн аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.2.3 дахь хэсэгт тусгагдсан тодорхой төрлийн гэмт хэргийн гаралтыг бууруулах зорилтын хүрээнд согтуугаар үйлдэгдэх гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж эхэлсэн Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийг сурталчлах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахад аймгийн Прокурорын газарт дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дэмжлэгт шаардагдах 10,000,000 (арван сая) төгрөгийг Засаг даргын хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг аймгийн Прокурорын газарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс (Б.Золжаргал), Хяналт- шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР